

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2026/150/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Санхүүгийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас:261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас:260512 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Бат-Эрдэнэ
Утас: 261885 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	9
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	19
4.1 Ерөнхий зүйл	19
4.2 Материаллаг байдал	19
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	19
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	24
5.1 Төлбөрийн акт	25
5.2 Албан шаардлага	25
5.3 Зөвлөмж	26
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	28

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУДШ	Монгол Улсын дээд шүүх
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
МЭГ	Монополын эсрэг газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
САГ	Санхүүгийн аудитын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



МОНОПОЛЫН ЭСРЭГ ГАЗРЫН
ДАРГА Б.БИЛГҮҮН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.25 № 06/350
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монополын эсрэг газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 216,426.0 мянган төгрөгийн зөрчил илэрч бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд судалгааны ажил гүйцэтгүүлэхдээ төсвийн нарийвчилсан тооцоолол, өртгийн судалгааг хийлгүйгээр гэрээний үнийг 500,000.0 мянган төгрөгөөр тогтоосон, гэрээгээр 7 нэр, төрлийн судалгааны ажил гүйцэтгүүлэхээр тусгасан боловч 2 судалгааны ажлын даалгаврыг боловсруулаагүй, гүйцэтгэгч тал гэрээнд заасан судалгааны ажлаас 2 ажлыг огт хийгээгүй, бусад судалгааны ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байхад урьдчилгаа төлбөрт 150,000.0 мянган төгрөгийг шилжүүлж гэрээний гүйцэтгэлийг хаасан. Мөн гэрээний нөхцөлд заасан хариуцлага, алдангийг тооцоогүй, хүлээн авсан судалгааны ажил тус бүрийн өртгийг тодорхойлох боломжгүй, тус судалгааны ажлуудыг тайлант онд шууд зардлаар бүртгэсэн;
- Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй, газар, хэлтсийн дарга нар албан хаагчдын тухай улирлын ажлын үр дүнг үнэлж

дүгнээгүй байхад төсөв захирагчийн тушаалаар тайлант оны 1 дүгээр улиралд 23,358.3 мянган төгрөгийн, 3 дугаар улиралд 19,885.7 мянган төгрөгийн нийт 43,244.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон;

- Цалингийн зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд албан хаагчдын цалинг тооцохдоо тайлант онд дотоод албан томилолтоор явсан нийт 18 албан хаагчдад хоол, унааны зардал 2,915.0 мянган төгрөгийг давхардуулан тооцож олгосон зэрэг нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.9 дахь заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.13 дахь хэсэгт заасны дагуу сонгуулийн сурталчилгаанд хяналт тавих чиг үүргийн хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооноос 2025 оны нөхөн сонгуулийн сурталчилгаанд хяналт хэрэгжүүлэхэд зориулан 9,830.5 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан зарцуулсан байна.

Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Орон тооны гишүүнийг чөлөөлөх, томилох тухай” 251 дүгээр тогтоолоор өмнө нь ажиллаж байсан орон тооны гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж орон тооны 2 гишүүнийг шинээр томилон ажиллуулсан байна.

Үүнтэй холбогдуулан дээрх Засгийн газрын шийдвэрийг эс зөвшөөрсөн маргааныг Захиргааны хэргийн дээд шүүх 2026 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр хэлэлцэн шийдвэрлэсэн боловч уг шүүхийн шийдвэр нь аудитын тайлан гаргах өдрөөр эцэслэн хүчин төгөлдөр болж албажаагүй байна.

Дээр дурдсан асуудлууд нь тайлант үеийн санхүүгийн тайлан, тодруулгад тусгагдсан бөгөөд аудитын санал дүгнэлтэд нөлөөлөхгүй боловч тайлангийн хэрэглэгчдийн анхааралд онцлон хүргэх шаардлагатай гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал юм. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд аудитын гол асуудлын талаар тусад нь дүгнэлт гаргаагүй болно.

Тайлант онд бүх төрлийн шатахуун импортлох болон бөөний, жижиглэнгийн худалдаа эрхэлж буй аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж АИ 92 шатахууны үнийг хэлцэн тогтоосон 11 аж ахуй нэгжид 48,490,908.7 мянган төгрөг, үнийг хэлцэн тогтооход дэмжиж оролцсон 10 аж ахуйн нэгжид 4,151,142.6 мянган төгрөгийн торгуулийг тус тус ногдуулсан байна.

Бусад асуудал

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 52 дугаар тогтоол, Монгол Улсын Шадар сайдын 2025 оны “Стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах тухай” 59 дүгээр тушаалын дагуу Монополын эсрэг газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг шинэчлэн баталсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлтийн үе шатанд бид дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт авч, дотоод аудитын үйл ажиллагааг энэхүү аудитад ашиглахгүй байхаар шийдвэрлэсэн болно.

Аудитын явцад илэрсэн зарим алдаа, зөрчлүүдийн шинж чанар, зөрчлийн дүнгээс харахад байгууллагын дотоод хяналтын тогтолцоо сул, зохих түвшинд хэрэгжихгүй байна. Иймд байгууллагын удирдлагаас дотоод хяналтын тогтолцоог сайжруулах, хяналтыг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

Дээр дурдсан асуудлууд нь аудитын дүгнэлтэд шууд нөлөөлөхгүй боловч цаашид тайлангийн хэрэглэгчид зайлшгүй анхаарах шаардлагатай. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад асуудлын хэсгийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	25,221,563.36	199,521,324.99
33	АВЛАГА	487,197.00	546,011.63
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	487,197.00	546,011.63
34	УРЬДЧИЛГАА	-	158,100,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	158,100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	24,734,366.36	40,875,313.36
35400	Хангамжийн материал	24,734,366.36	40,875,313.36
35410	Бичиг хэргийн материал	5,514,556.36	5,852,691.36
35420	Аж ахуйн материал	13,420,770.00	25,530,273.00
35430	Сэлбэг хэрэгсэл	319,000.00	329,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	550,000.00
35470	Бусад хангамжийн материал	5,480,040.00	8,613,349.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,256,429,652.06	1,156,784,200.29
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,256,429,652.06	1,156,784,200.29
39200	Биет хөрөнгө	247,029,652.06	143,644,200.29
39203	Авто-тээврийн хэрэгсэл	59,500,000.00	59,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(4,958,333.34)	(59,500,000.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	243,577,818.00	219,411,618.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(109,642,290.93)	(133,357,670.92)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	82,681,679.00	81,716,211.32
39208	Хуримтлагдсан элэгдэл	(24,129,220.67)	(24,125,958.11)
39300	Биет бус хөрөнгө	1,009,400,000.00	1,013,140,000.00
39301	Программ хангамж	6,540,000.00	5,040,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,020,000.00)	(3,780,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,006,880,000.00	1,011,880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	1,281,651,215.42	1,356,305,525.28
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	528,001.00	19,721,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	528,001.00	19,721,000.00
41300	Өглөг	528,001.00	19,721,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	528,001.00	-
41360	Бусад өглөг	-	19,721,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	1,250,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	18,471,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,281,123,214.42	1,336,584,525.28
51	Засгийн газрын хувь оролцоо	1,281,123,214.42	1,336,584,525.28
51200	Хуримтлагдсан үр дүн	1,281,123,214.42	1,336,584,525.28
51210	Өмнөх үеийн үр дүн	1,203,334,444.96	1,286,123,214.42
51220	Тайлант үеийн үр дүн	77,788,769.46	50,461,310.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	1,281,651,215.42	1,356,305,525.28

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,956,588,184.00	2,556,179,080.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,556,179,080.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	830,000.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	-	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	-
120009	Бусад орлого	-	140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	-	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	-	690,000.00
122	Тусламжийн орлого	-	2,555,349,080.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,555,349,080.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,545,518,600.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,545,518,600.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,830,480.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,830,480.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,956,588,184.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,807,577,400.00	-
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,807,577,400.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,010,784.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	149,010,784.00	-
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,878,799,414.54	2,505,222,769.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,878,799,414.54	2,505,222,769.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,800,613,573.69	2,384,224,437.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,160,344,661.95	1,387,092,570.99
210101	Үндсэн цалин	635,510,302.49	688,749,978.55
210102	Нэмэгдэл	300,599,836.63	357,173,123.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	153,749,722.80	239,298,182.19
210104	Урамшуулал	70,484,800.03	101,871,286.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	155,272,047.43	180,161,549.86
210201	Тэтгэврийн даатгалын зардал	102,849,801.00	122,326,149.86
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	12,577,834.11	14,458,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	6,951,000.00	7,229,600.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	8,817,712.32	7,229,600.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	24,075,700.00	28,917,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,192,000.00	2,571,300.00
210304	Байрны түрээс	3,192,000.00	2,571,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	77,385,386.28	105,835,876.58
210401	Бичиг хэрэг	33,346,899.14	34,444,045.86
210402	Тээвэр, шатахуун	7,003,248.00	23,700,960.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,065,038.14	27,860,709.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	16,970,201.00	19,830,161.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,244,200.00	86,393,104.00
210604	Урсгал засвар	3,244,200.00	86,393,104.00

2107	Томилолт, зочны зардал	-	13,880,000.00
210702	Дотоод албан томилолт	-	13,880,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	354,767,926.84	482,427,084.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	335,451,715.84	377,974,890.00
210803	Даатгалын үйлчилгээ	8,748,000.00	9,694,420.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,200.00	245,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,224,057.00	94,195,020.00
210807	Газрын төлбөр	294,954.00	294,954.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,407,351.19	125,862,951.73
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,129,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	3,040,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,407,351.19	117,693,051.73
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,185,840.85	120,998,331.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	91,156,331.94
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	91,156,331.94
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	91,156,331.94
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	91,016,331.94
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал\	-	140,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,615,000.00	29,842,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,615,000.00	2,371,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	27,471,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,570,840.85	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,570,840.85	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	77,788,769.46	50,956,310.90
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	495,000.04
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	-	495,000.04
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	-
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-	(495,000.04)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	77,788,769.46	50,461,310.86

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,956,588,184.00	2,555,489,080.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	2,555,489,080.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	140,000.00
120009	Бусад орлого	-	140,000.00
122	Тусламжийн орлого	-	2,555,349,080.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	2,555,349,080.00
12211	Харьяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого	-	2,545,518,600.00
122111	Урсгал санхүүжилтийн орлого	-	2,545,518,600.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,830,480.00
122135	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,830,480.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,956,588,184.00	-
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,807,577,400.00	
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,807,577,400.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	149,010,784.00	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	149,010,784.00	
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,834,323,624.00	2,555,489,080.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,834,323,624.00	2,555,489,080.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,755,554,783.15	2,449,661,748.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,159,270,561.67	1,387,674,126.62
210101	Үндсэн цалин	635,510,302.49	689,331,534.18
210102	Нэмэгдэл	299,525,736.35	357,173,123.65
210103	Унаа хоолны хөнгөлөлт	153,749,722.80	239,298,182.19
210104	Урамшуулал	70,484,800.03	101,871,286.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	150,473,300.00	180,166,809.86
210201	Тэтгэврийн даатгалын зардал	102,321,800.00	122,331,409.86
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	11,105,800.00	14,458,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	6,951,000.00	7,229,600.00
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	6,019,000.00	7,229,600.00
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	24,075,700.00	28,917,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,192,000.00	7,267,300.00
210304	Байрны түрээс	3,192,000.00	7,267,300.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,440,300.00	76,914,393.58
210401	Бичиг хэрэг	7,684,800.00	23,558,960.86
210402	Тээвэр, шатахуун	3,400,000.00	17,420,480.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,523,996.00	28,636,409.72
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,831,504.00	7,298,543.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,999,200.00	119,863,834.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,513,200.00	15,967,980.00
210604	Урсгал засвар	7,486,000.00	103,895,854.00
2107	Томилолт, зочны зардал	-	18,150,380.00
210702	Дотоод албан томилолт	-	18,150,380.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	400,179,421.48	641,809,904.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	375,345,210.48	527,004,810.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	8,748,000.00	17,794,420.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	49,200.00	245,800.00

Монополийн эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,742,057.00	96,447,920.00
210807	Газрын төлбөр	294,954.00	294,954.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	17,815,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	17,815,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	78,768,840.85	105,827,331.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	91,156,331.94
21311	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	91,156,331.94
213112	Төсвийн байгууллагаас харьяа төрийн санруу төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	91,156,331.94
2131121	Санхүүжилтийг үлдэгдлээс төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	91,016,331.94
2131122	Төсвийн дансны төсвийн орлогод тооцох төвлөрүүлэх шилжүүлгийн зардал	-	140,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	26,198,000.00	14,671,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	25,198,000.00	5,671,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	9,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	52,570,840.85	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	52,570,840.85	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	122,264,560.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	122,264,560.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	122,264,560.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	122,264,560.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	122,264,560.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(122,264,560.00)	-
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны нэр, төрөл	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,808,521.00	-	1,016,525,923.96	1,203,334,444.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(186,808,521.00)	-	186,808,521.00	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,203,334,444.96	1,203,334,444.96
Тайлант үеийн үр дүн	-	-	77,788,769.46	77,788,769.46
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,281,123,214.42	1,281,123,214.42
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	5,000,000.00	5,000,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	1,286,123,214.42	1,286,123,214.42
Тайлант үеийн үр дүн	-	-	50,461,310.86	50,461,310.86
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	1,336,584,525.28	1,336,584,525.28

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	2,989,442,500.00	2,454,502,268.06	534,940,231.94	82.1
12	Татварын бус орлого	2,989,442,500.00	2,454,502,268.06	534,940,231.94	82.1
122	Тусламжийн орлого	2,989,442,500.00	2,454,502,268.06	534,940,231.94	82.1
122005	Төсвөөс санхүүжих	2,989,442,500.00	2,454,502,268.06	534,940,231.94	82.1
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,989,442,500.00	2,454,502,268.06	534,940,231.94	82.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,989,442,500.00	2,454,502,268.06	534,940,231.94	82.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,972,971,500.00	2,439,831,268.06	533,140,231.94	82.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,424,211,000.00	1,387,674,126.62	36,536,873.38	97.4
210101	Үндсэн цалин	745,068,300.00	689,331,534.18	55,736,765.82	92.5
210102	Нэмэгдэл	424,989,800.00	357,173,123.65	67,816,676.35	84.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	141,532,000.00	239,298,182.19	(97,766,182.19)	169.1
210104	Урамшуулал	112,620,900.00	101,871,286.60	10,749,613.40	90.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	180,735,300.00	180,166,809.86	568,490.14	99.7
210201	Тэтгэврийн даатгал	122,899,900.00	122,331,409.86	568,490.14	99.5
210202	Тэтгэмжийн даатгал	14,458,900.00	14,458,900.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,229,600.00	7,229,600.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	7,229,600.00	7,229,600.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	28,917,300.00	28,917,300.00	-	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,658,900.00	7,267,300.00	9,391,600.00	43.6
210301	Гэрэл, цахилгаан	266,800.00	-	266,800.00	-
210304	Байрны түрээс	16,392,100.00	7,267,300.00	9,124,800.00	44.3
2104	Хангамж, бараа материалын зардал	117,252,500.00	76,914,393.58	40,338,106.42	65.6
210401	Бичиг хэрэг	33,134,200.00	23,558,960.86	9,575,239.14	71.1
210402	Тээвэр, шатахуун	24,200,000.00	17,420,480.00	6,779,520.00	72.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	45,131,900.00	28,636,409.72	16,495,490.28	63.5
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,786,400.00	7,298,543.00	7,487,857.00	49.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	121,749,400.00	119,863,834.00	1,885,566.00	98.5
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,852,400.00	15,967,980.00	(12,115,580.00)	414.5
210604	Урсгал засвар	117,897,000.00	103,895,854.00	14,001,146.00	88.1
2107	Томилолт, зочны зардал	8,599,900.00	8,319,900.00	280,000.00	96.7
210702	Дотоод албан томилолт	8,599,900.00	8,319,900.00	280,000.00	96.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,085,949,500.00	641,809,904.00	444,139,596.00	59.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	970,928,900.00	527,004,810.00	443,924,090.00	54.3

Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	17,836,700.00	17,794,420.00	42,280.00	99.8
210804	Тээврийн хэрэгслийн татвар	299,800.00	245,800.00	54,000.00	82.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	36,300.00	22,000.00	14,300.00	60.6
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	96,448,300.00	96,447,920.00	380.00	100.0
210807	Газрын төлбөр	399,500.00	294,954.00	104,546.00	73.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,815,000.00	17,815,000.00	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	17,815,000.00	17,815,000.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,471,000.00	14,671,000.00	1,800,000.00	89.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,471,000.00	14,671,000.00	1,800,000.00	89.1
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,671,000.00	5,671,000.00	-	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,800,000.00	9,000,000.00	1,800,000.00	83.3
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ				
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	33	32	1	97.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	29	25	4	86.2
620003	Үйлчлэх ажилтан	3	6	(3)	200.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	-	9,830,480.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	9,830,480.00
122	Тусламжийн орлого	-	9,830,480.00
1221	Хандив тусламж /дотоод/	-	9,830,480.00
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	9,830,480.00
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	9,830,480.00
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	9,830,480.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	9,830,480.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	9,830,480.00
2107	Томилолт, зочны зардал	-	9,830,480.00
210702	Дотоод албан томилолт	-	9,830,480.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Монополийн эсрэг газрын стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 59 дүгээр тогтоолоор баталж, эрхэм зорилгыг зах зээлд шударга өрсөлдөөний таатай орчин бүрдүүлэх, өрсөлдөөний бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хууль бус зар сурталчилгааг хориглох төрийн бодлого тодорхойлж, хэрэгжүүлэх, улс орны эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, зах зээлийн эдийн засгийн зөв тогтолцоог хөгжүүлнэ хэмээн тодорхойлсон байна.

Монополийн эсрэг газар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн зах зээлийн өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчийн эрхийг хамгаалах, хууль бус зар сурталчилгааг хориглох талаарх бодлогыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөгөө, бүх талын дэмжлэгээр хангах замаар Засгийн газрын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, удирдлагын зохистой хэлбэр төлөвшүүлэхэд чиглэн үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Монополийн эсрэг газар нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Өрсөлдөөний тухай хууль, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хууль, Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон тус хуулиар харьяалуулсан бусад хууль, эрх зүйн актын хүрээнд үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Зөрчлийн тухай хууль;
- Зар сурталчилгааны тухай хууль;
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль;
- Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль;
- Засгийн газрын 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Томилолтын зардлыг шинэчлэн тогтоох тухай” 133 дугаар тогтоол;
- Засгийн газрын 2025 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 224 дүгээр тогтоол;
- Сангийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”;
- Сангийн сайдын 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн “Төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай” 112 дугаар тушаал;

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитын төлөвлөлийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголттой болсон бөгөөд дотоод аудитын үйл ажиллагааг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн. Аудитын явцад дотоод хяналтын үйл ажиллагаанд горим сорил хэрэгжүүлэхэд дотоод хяналтын төлөвлөгөө, ажлын тайлан байхгүйгээс гадна аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн дүнгээс харахад тус байгууллагын дотоод хяналтын тогтолцоо сул, зохих түвшинд хэрэгжихгүй байна.

Иймд төсөв захирагч дотоод хяналтын тогтолцоог сайжруулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлагатай байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/87 дугаар тушаалаар баталж, санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирч байгаа боловч шинээр батлагдсан хууль, журмын өөрчлөлтүүдийг тусгаагүй бодлогын баримт бичигт шинэчлэлт хийгээгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Монополын эсрэг газар нь 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 74,654.3 мянган төгрөгөөр буюу 5.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	487.2	546.0	58.8
Урьдчилгаа	-	158,100.0	158,100.0
Бараа материал	24,734.4	40,875.3	16,140.9
Үндсэн хөрөнгө	1,256,429.7	1,156,784.2	(99,645.5)
Нийт хөрөнгө	1,281,651.2	1,356,305.5	74,654.3
Өр төлбөр	528.0	19,721.0	19,193.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,281,123.2	1,336,584.5	55,461.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,281,651.2	1,356,305.5	74,654.3

Дээрх хүснэгтэс харахад дансны үлдэгдэлд нөлөө бүхий дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өмнөх оноос 158,100.0 мянган төгрөгөөр өссөн нь албан хаагчдын амь нас, эрүүл мэндийн даатгалын үйлчилгээний 16,200.0 мянган төгрөгийн төлбөрийг тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрснийг санхүүгийн тайлангийн аудитаар залруулж тухайн онд ногдох хэсгийг зардлаар, 2026 онд ногдох 8,100.0 мянган төгрөгийн төлбөрийг урьдчилж гарсан зардлаар бүртгүүлсэн, мөн 150,000.0 мянган төгрөгийн гэрээний үнэтэй судалгааны ажлыг хөрөнгөөр бүртгэлгүйгээр тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрснийг аудитын явцад залруулж урьдчилж төлсөн зардлаар бүртгүүлсэн;
- Тайлант хугацаанд 97,456.0 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 81,315.0 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан бөгөөд бараа материал дансны үлдэгдэл өмнөх оноос 16,140.9 мянган төгрөгөөр өссөн нь 8,530.0 мянган төгрөгийн хөшиг худалдан авсан, мөн архивын улсын үзлэгийн бэлтгэл ажилтай холбоотой худалдан авалт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 99,645.5 мянган төгрөгөөр буурсан нь ТӨБЗГ-ын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А-4/2700 тоот зөвшөөрлийн дагуу 40,174.3 мянган төгрөгийн хөрөнгийг данс, бүртгэлээс хассан болон тайлант онд 117,693.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон нь голлон нөлөөлсөн;
- Өр төлбөр дансны үлдэгдэл өмнөх оноос 19,193.0 мянган төгрөгөөр өсөж 19,721.0 мянган төгрөг болсон нь ажлаас түр чөлөөлөгдсөн 3 албан хаагчид олгох 16,671.0 мянган төгрөгийн нөхөх төлбөр, санхүүжилтийн эрх нээгдээгүйтэй холбоотой байгууллагад өгөх 1,250.0 мянган төгрөгийн, мөн ахмадуудад хүндэтгэл үзүүлэхтэй холбоотой 1,800.0 мянган төгрөгийн өглөг үүссэн;

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,155,741.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,155,741.2 мянган төгрөгөөр тус тус тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас нийт зардлыг 962,588.6 мянган төгрөгөөр өсгөж, 4,118,329.8 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардалд 2,250,000.0 мянган төгрөгийн төсвийг нэмэлтээр баталж бусад зардлын хувьд 2024 оны баталсан төсвийг төсвийн хязгаар болгон хянасантай холбоотой байна.

Тайлант оны батлагдсан төсвийг 1,128,887.3 мянган төгрөгөөр бууруулан тодотгосон байна.

Төсвийн төлөвлөлтийн тухайд төсөв захирагчийн саналыг харгалзан үзэлгүйгээр батлагдсан төсвийг бууруулан тодотгосон, төсвийн тодорхой хэсэгт Монгол Улсын Ерөнхий сайдын 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 05 дугаар “Төсвийн сахилга бат хариуцлагыг чангатгах тухай” албан даалгавартай холбогдуулан санхүүжилтийн эрх нээгээгүй зэрэг нь төсвийн төлөвлөлт, зарцуулалтад хүндрэл үүссэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “зах зээлийн өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийн хамгаалалт” хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр, батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс 2,545,518.6 мянган төгрөгийн, бусад эх үүсвэрээс 140.0 мянган төгрөгийн нийт 2,545,658.6 мянган төгрөгийн эх үүсвэрээс 2,454,502.3 мянган төгрөгийг зарцуулан 91,156.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,454,502.3 мянган төгрөг буюу 82.1 хувьтай байгаа нь хангамж бараа, материалын зардлын төсвийг 40,920.1 мянган төгрөгөөр, цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлын төсвийг 36,536.9 мянган төгрөгөөр, байрны түрээсийн зардлын төсвийг 9,391.6 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлын төсвийг 1,800.0 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлын төсвийг 568.5 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх зардлын төсвийг 289.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Мөн төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэхтэй холбоотой бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын төсвөөс 437,358.9 мянган төгрөгийн санхүүжилтийг олгоогүй байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ		Төлөвлөгө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70410-	Зах зээлийн өрсөлдөөн хэрэглэгчийн эрхийн хамгаалалт		2,989,442.5	2,454,502.3	534,940.2	82.1
1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,984,227.6	1,895,011.5	89,216.1	95.5
2	80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	19,997.7	19,500.1	497.6	97.5
3	80226	Байр ашиглалтын үйлчилгээ	318,246.3	312,178.7	6,067.6	98.1
4	80802	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал, дэмжлэг	16,471.0	14,671.0	1,800.0	89.1
5	81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	632,684.9	195,326.0	437,358.9	30.9
6	82313	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр	17,815.0	17,815.0	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Судалгааны үр дүн: Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу аудитын явцад тус байгууллагаас дараах зардлын судалгааг авч, үр дүнг дүгнэлээ. Үүнд:

- Бүтэц, орон тооны талаар: Төрийн албан хаагчийн есөн хувийн цомхотгох бодлогын хүрээнд анх батлагдсан орон тооноос 3 орон тоог цомхотгож тайлант онд 33 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан бөгөөд цалингийн зардал 36,536.9 мянган төгрөгөөр хэмнэгдсэн;

- Унаа, хоолны хөнгөлөлтийн талаар: Тус газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/34 дүгээр тушаалаар ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 24.0 мянган төгрөгөөр, унааны нөхөх төлбөрийг 1.0 мянган төгрөгөөр баталсанг 2025 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А/44 дүгээр тушаалаар шинэчлэн баталж ажлын нэг өдрийн хоолны нөхөх төлбөрийг 33.0 мянган төгрөг, унааны нөхөх төлбөрийг 2.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Үүнээс шалтгаалан унаа, хоолны нөхөн олговрын төсөв батлагдсан төсвөөс 97,766.2 мянган төгрөгөөр илүү зарцуулагдсан;
- Тайлант онд гадаад томилолт, сургалт, семинар, хурал зөвлөгөөн, хэвлэл мэдээлэлийн байгууллагуудтай байгуулсан ажил үйлчилгээний төлбөр, төрд учирсан хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой төсвөөс зардал гараагүй байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сонгуулын ерөнхий хорооны 2025 оны А/26 тоот захирамжаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.13 дахь хэсэгт заасны дагуу 2025 оны нөхөн сонгуулийн сурталчилгаанд хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг хангуулж ажиллуулахтай холбоотой 9,830.5 мянган төгрөгийн санхүүжилтийг нэмэлт санхүүжилтийн дансанд олгосон бөгөөд тайлант онд батлагдсан төсвийг бүрэн зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 01 дүгээр сарын 7-ны өдөр баталсан ТЕЗ-ын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд Монополийн эсрэг газрын худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төсвийг 1,972,300.0 мянган төгрөгөөр баталсан бөгөөд тайланд онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг төсөл, арга хэмжээ бүрээр төлөвлөлөгүүгээр бөөн дүнгээр төлөвлөн баталсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2025 оны 8 дугаар сарын 18-ны өдөр өөрчлөлт орж тус байгууллагын худалдан авах ажиллагааны төсөв 974,300.0 мянган төгрөг болон буурсан байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дараах нэмэлт өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Мэдээлэл технологийн үйлчилгээний төсөвт өртөг 154,400.0 мянган төгрөгөөс 49,200.0 мянган төгрөгөөр нэмэгдэж 203,600.0 мянган төгрөг болсон;
- Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх ажлын төсөвт өртөг 1,800,000.0 мянган төгрөгөөс 1,167,200.0 мянган төгрөгөөр буурч 632,800.0 мянган төгрөг болсон;
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 20,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Эрдэм шинжилгээ судалгааны ажил, 100,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй урсгал засварын ажил тус тус нэмэгдсэн;

Худалдан авах ажиллагааны тайланг 2026 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн албан бичгээр МУ-ын Шадар сайдын ажлын албанд хүргүүлсэн бөгөөд гүйцэтгэлээр 84,690.1 мянган төгрөгийн 1 худалдан авалтад НТШ, 72,960.0 мянган төгрөгийн 4 худалдан авалтад харьцуулалтын арга, 257,103.8 мянган төгрөгийн 12 худалдан авалтад шууд худалдан авалтын аргыг тус тус ашиглан тайлант онд нийт 414,753.0 мянган төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авснаар тайлагнасан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Монополын эсрэг газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Монополын эсрэг газар, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Э.Бат-Эрдэнэ гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 01/169 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайланг, суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны нийт зардлын дүн 1,878,799.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 18,787.9 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төсвийн шууд захирагчийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга батыг мөрдүүлж, ил тод байдлыг хангах, үр ашгийг нэмэгдүүлэх, үрэлгэн байдлыг хязгаарлах, хяналт тавихтай зорилготой Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан уг хуульд хориглосон хэвлэл захиалгын төлбөр, байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах, төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах зэрэг зардлуудад тайлант хугацаанд төсөв зарцуулаагүй байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн төсөв 91,156.3 мянган төгрөгөөр хэмнэгдэж улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн бөгөөд уг хэмнэлтэд орон тоог бууруулснаар цалингийн зардал 36,536.9 мянган төгрөгөөр, байрны түрээсийн зардал 9,391.6 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардал 1,800.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Мөн Сангийн яамнаас санхүүжилтийн эрх олгоогүйгээс Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх зардлын төсвөөс 437,358.9 мянган төгрөгийг зарцуулаагүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 315,103.2 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 2 зөвлөмж өглөө.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 47,033.9 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй нийт 156,483.9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 9 худалдан авалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4 "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаягийн үнэн зөв иж бүрэн мэдээлнэ", 6.4.5 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр”, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 3.2.9 “таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээг гэрээ, хэлцэл, санхүүжилт өгснөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 8 дугаар хавсралтад заасан маягтын дагуу цахимаар”, 3.2.10 “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ бүрийг холбогдох шийдвэрийн хуулбарын хамт тухайн гүйлгээ хийгдсэнээс хойш 7 хоногийн дотор энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан маягтын дагуу цахимаар” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд тогтоосон хугацаанд үнэн зөв мэдээлж байх зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тайлант онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тендер шалгаруулалтын арга, төсөл, арга хэмжээ нэг бүрээр тусгаагүй бөөн дүнгээр нэгтгэж төлөвлөсөн, зарим төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан байна. Мөн тайлант онд худалдан авсан 59,010.3 мянган төгрөгийн гэрээний дүнтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны тайланд тусгаагүй, тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт

туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна", 46 дугаар зүйлийн 46.1-д "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна", 2.11-т "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна", 2.19-т "Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг энэ журамд заасны дагуу цахим системд бүрэн оруулж, батлуулаагүй нь хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болно", 3.11-т "Захиалагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны тайланг цахим системд бүрэн оруулж, батлуулаагүй нь хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тендер шалгаруулалтын арга, төсөл, арга хэмжээ нэг бүрээр тусгаж, бүрэн тайлагнаж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2.2. Тайлант онд ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах 52,575.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", 37 дугаар зүйлийн 37.1.2-т "хоёрдугаар үе шатанд захиалагч бараа, үйлчилгээг үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авах", 38.1-д "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна", 49 дүгээр зүйлийн 49.4.3-т "ерөнхий гэрээ байгуулахтай холбоотойгоор энэ хуулийн 48.2.11-д зааснаас бусад захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах

ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 162 дугаар тушаалын 3-т “Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн худалдан авах ажиллагааны газарт бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг хүргүүлж худалдан авах ажиллагааг зохион байгуулах, цахим дэлгүүрээс худалдан авах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2.3. Тус газар нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим гэрээнд ерөнхий байдлаар тусгасан, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдээгүй, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 24 дүгээр зүйлийн 24.6-д “Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана”, 12.2-т “Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно”, Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.2-т “Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, төсвийн тооцоог боловсруулж байх, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдэж байх албан шаардлага хүргүүлэв.

4.4.2.4. Хууль, хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод хяналтын хэлтэс нь чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хяналт шалгалт хэрэгжүүлэх тухайн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байгууллагын дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан

гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хяналт шалгалт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж, төлөвлөгөөний дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тус байгууллагын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 53,315.2 мянган төгрөгийн 3 зөрчлийг илрүүлж, үүнээс 34,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага, тайлант онд авлга, өр төлбөр үүсгэсэн болон худалдан авалттай холбоотой 2 зөвлөмжийг тус тус хүргүүлсэн байна.

Өмнөх жилийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмж бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	34,000.0	1	34,000.0	100.0
Зөвлөмж	2	19,315.2	2	19,315.2	100.0
Нийт дүн	3	53,315.2	3	189,910.2	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын хавсралтад заасан маягтын дагуу бэлтгэхээр зохицуулсан боловч "Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн систем" дэх тайлангийн зарим үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байгааг цаашид анхаарах нь зүйтэй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 227,855.5 мянган төгрөгийн 6 алдаа¹ илэрснээс аудитын явцад бүрэн залрууллаа.

Залруулсан алдаа:

- Тайлант онд 500,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 150,000.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж 5 нэр төрлийн судалгааны ажил гүйцэтгүүлэн, тайланг хүлээн авсан боловч захиалагч нь оюуны өмчийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн холбогдох дансанд стандартын дагуу нэр, төрлөөр бүртгэлгүй шууд зардлаар бүртгэсэн;
- Тайлант онд худалдан авсан 40,546.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй программ хангамжийн эрхийн сунгалтуудтай холбоотой зардлыг бараа материалаар бүртгэсэн;
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд олгох шимтгэлийн зардал 4,940.5 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалингийн зардал 14,667.2 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн;
- Тайлант онд албан хаагчдын амь нас эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд зориулж 16,200.0 мянган төгрөгийн гэрээг Номин даатгал ХХК-тай байгуулсан бөгөөд тайлант оны зардалд хамаарахгүй 8,100.0 мянган төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрсөн;
- Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг 2023 онд 5,000.0 мянган төгрөгөөр хийлгэсэн боловч одоог хүртэл санхүүгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй, хөрөнгөөр бүртгээгүй;
- Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг давтан шалгахад тайлант онд элэгдлийн зардлын дүнг 4,602.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон зэрэг алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.3 "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", УСНББОУС 1, УСНББОУС 19, УСНББОУС 24, УСНББОУС 31 дэх заалтуудтай тус тус нийцээгүй байна.

Аудитаар нийт 216,426.0 мянган төгрөгийн зөрчил² илэрсэнд, 2,915.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 150,000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 63,511.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн 216,426.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 18,787.9 мянган төгрөгөөс их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Цалингийн зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд албан хаагчдын цалинг тооцохдоо тайлант онд дотоод албан томилолтоор явсан 18 албан хаагчдад 2,915.0 мянган төгрөгийн хоол, унааны зардлыг давхардуулан тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам” 2.1-д “Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно”, 2.2-д “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал, 2.2.2. байрны зардал, 2.2.3. хоолны зардал” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Томилолтоор ажилласан албан хаагчдад давхардуулан олгосон 2,915.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэх төлбөрийн акт тогтоолоо.

5.2 Албан шаардлага

5.2.1 Төсөв захирагч нь Монгол Улсын Их Сургуультай 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдөр 500,000.0 мянган төгрөгийн үнийн дүн бүхий судалгааны ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан боловч гэрээнд тусгасан нийт 7 нэр, төрлийн судалгааны ажлаас 2 судалгааны ажлын даалгаврыг боловсруулаагүй, төсвийн нарийвчилсан тооцоолол, өртгийн судалгааг хийлгүйгээр гэрээний үнийг шууд тогтоосон байна.

Мөн гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссан байхад талууд гэрээг дүгнээгүй, аудит гүйцэтгэж байх хугацаанд нэмэлт гэрээ нөхөж байгуулсан, судалгааны ажлаас 2 ажлыг огт хийгээгүй байхад төсөв захирагч төлбөрийг бүрэн олгохыг үүрэг болгосон, түүнчлэн бусад судалгааны ажлуудыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байхад алданги тооцоогүй, гэрээнд оюуны өмчийг эзэмших, ашиглах, баталгаажуулах, хориглох нөхцөл болон талуудын хооронд тохирсон бусад асуудлын талаар тусгаагүй. Үүний улмаас хүлээн авсан 5 судалгааны ажил тус бүрийн өртөг, үнийн дүнг тодорхойлох боломжгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана”, 12 дугаар зүйлийн 12.2-т “Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20 дугаар зүйлийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”, Засгийн газрын 2015 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан “Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион

бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам"-ын 4.2-т "Гэрээнд төслийг хэрэгжүүлэх хугацаа, нөхцөл, зардал, хүрэх үр дүн, оюуны өмч, түүнийг эзэмших, ашиглах, баталгаажуулах нөхцөл, оюуны өмчийг ашиглахыг хориглох нөхцөл, журам, лицензийн нөхцөлөөр ашиглуулах болон талуудын хооронд тохирсон бусад асуудлыг тусгана", 4.6-д "Захиалагч нь оюуны өмчийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн холбогдох дансанд олон улсын ангилал, стандартын дагуу нэр, төрлөөр нь бүртгэж элэгдэл, хорогдлыг тооцно", 5.2-т "Энэ журмын 5.1-д зааснаас бусад үр дүн буюу оюуны өмчтэй холбогдох тайлан, зураг, программ хангамж, интеграл микросхемийн зураглал, ноу-хау зэргийг төслийн захиалагч эзэмшиж, ашиглана", Монополийн эсрэг газар болон Монгол Улсын Их сургуулийн 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан 2025/Г-12 дугаар гэрээний 2.2-т "Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа ажлын 90 хоног", 3.1-т "Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 500,000.0 мянган төгрөг байна", 3.3-т "Гүйцэтгэгч тал ажлыг бүрэн гүйцэтгэж захиалагч талд хүлээлгэн өгснөөр гэрээт ажлын үлдэгдэл 70 хувийн төлбөрийг ажлын 5 хоногт багтаан гүйцэтгэгч талын дансанд шилжүүлнэ", 5.1-т "Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ", 6.1-т "Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.5 хувийн алданги төлнө", 6.2-т "Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүдэн нөгөө талд болон бусдад учирсан хохирол, зардлыг бүрэн хариуцаж барагдуулна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн хөрөнгөөр судалгааны ажил гүйцэтгүүлэхдээ ажлын даалгаврыг бүрэн боловсруулж, төсвийн тооцоолол, өртгийн судалгаа хийж гэрээний үнийг бодитой тогтоох, мөн гэрээнд заасан хугацаанд ажлыг комиссын акт үйлдэн хүлээн авч гэрээ дүгнэсэн акт үйлдэж байх албан шаардлага хүргүүлээ.

5.3 Зөвлөмж

5.3.1 Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй, газар, хэлтсийн дарга албан хаагчдын тухайн улирлын ажлын үр дүнг үнэлж дүгнээгүй байхад төсөв захирагчийн тушаалаар тайлант оны 1 дүгээр улиралд 23,358.3 мянган төгрөгийн, 3 дугаар улиралд 19,885.7 мянган төгрөгийн нийт 43,244.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2. "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараахь эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно", 1.2.2 "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид", 2.1 "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдад улирлын үр дүнгийн урамшуулал олгохдоо гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргуулан, гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн олгож байх.

5.3.2 Тайлант онд албан хаагчдаас авах авлага 546.0 мянган төгрөг, байгууллагад өгөх өглөг 1,250.0 мянган төгрөг, албан хаагчид өгөх өглөг 18,471.0 мянган төгрөг, нийт 19,721.0 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 6.4.8 “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайлант онд төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Дээрх шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Тайлант онд 500,000.0 мянган төгрөгийн гэрээ байгуулж 150,000.0 мянган төгрөгийг урьдчилан шилжүүлж 5 нэр төрлийн судалгааны ажил гүйцэтгүүлэн, тайланг хүлээн авсан боловч захиалагч нь оюуны өмчийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн холбогдох дансанд стандартын дагуу нэр, төрлөөр бүртгэлгүй шууд зардлаар бүртгэсэн	1	150,000.0	-	-	1	150,000.0	1	150,000.0	-	-	-	-
Тайлант онд худалдан авсан 40,546.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй программ хангамжийн эрхийн сунгалтуудтай холбоотой зардлыг бараа материалаар бүртгэсэн	1	40,546.1	-	-	1	40,546.1	1	40,546.1	-	-	-	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд олгох шимтгэлийн зардал 4,940.5 мянган төгрөгөөр, нэмэгдэл цалингийн зардал 14,667.2 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн	1	19,607.3	-	-	1	19,607.3	1	19,607.3	-	-	-	-
Албан хаагчдын амь нас эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд зориулж 16,200.0 мянган төгрөгийн гэрээг	1	8,100.0	-	-	1	8,100.0	1	8,100.0	-	-	-	-

Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Номин даатгал ХХК-тай байгуулсан бөгөөд тайлант оны зардалд хамаарахгүй 8,100.0 мянган төгрөгийг зардлаар хүлээн зөвшөөрсөн													
Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг 2023 онд 5,000.0 мянган төгрөгөөр хийлгэсэн боловч одоог хүртэл санхүүгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрөөгүй, хөрөнгөөр бүртгээгүй	1	5,000.0	1	5,000.0	-	-	1	5,000.0	-	-	-	-	-
Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг давтан шалгахад тайлант онд элэгдлийн зардлын дүнг 4,602.0 мянган төгрөгөөр дутуу тооцоолсон	1	4,602.0	-	-	1	4,602.0	1	4,602.0	-	-	-	-	-
Дүн	6	227,855.5	1	5,000.0	5	222,855.5	6	227,855.5	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Судалгааны ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулахдаа зарим судалгааны ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг боловсруулаагүй, гэрээний үнийн дүнг төсвийн тооцоолол хийгээгүй, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй	1	150,000.0	-	-	1	150,000.0	-	-	-	-	-	-
Албан хаагчид гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргаагүй, газар, хэлтсийн дарга албан хаагчдын тухайн улирлын ажлын үр дүнг үнэлж дүгнээгүй байхад төсөв захирагч тушаалаар үр дүнгийн урамшуулал олгосон	1	43,244.0	-	-	-	-	1	43,244.0	-	-	-	-
Тайлант онд авлага, өр төлбөр үүсгэсэн	1	20,267.0	-	-	-	-	1	20,267.0	-	-	-	-
Цалингийн зардлаас томиллоор ажилласан албан хаагчдад унаа, хоолны мөнгийг давхардуулан олгосон.	1	2,915.0	1	2,915.0	-	-	-	-	-	-	-	-
Дүн	4	216,426.0	1	2,915.0	1	150,000.0	2	63,511.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Тайлант онд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 47,033.9 мянган төгрөгийн зарлагын 5 гүйлгээ, 5 сая төгрөгөөс дээш гэрээний дүнтэй нийт 156,483.9 мянган төгрөгийн үнийн дүн бүхий 9 худалдан авалтын мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хуульд заасан хугацаанд үнэн зөв, иж бүрэн, ил тод мэдээлээгүй	1	203,517.8	-	-	1	203,517.8
Дүн	1	203,517.8	-	-	1	203,517.8
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тайлант онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тендер шалгаруулалтын арга, төсөл, арга хэмжээ нэг бүрээр тусгаагүй бөөн дүнгээр нэгтгэж төлөвлөсөн, зарим төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан, тайлант онд худалдан авсан 59,010.3 мянган төгрөгийн гэрээний дүнтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны тайланд тусгаагүй, тайлагнаагүй байна.	1	59,010.3	1	59,010.3	-	-
Тайлант онд ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах 52,575.1 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авсан	1	52,575.1	1	52,575.1	-	-
Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим гэрээнд ерөнхий байдлаар тусгасан, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдээгүй, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул	1	-	1	-	-	-
Хууль, хяналт-шинжилгээ үнэлгээ дотоод хяналтын хэлтэс нь чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлэх хяналт шалгалт хэрэгжүүлэх тухайн жилийн ажлын төлөвлөгөө боловсруулаагүй, хяналтын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байгууллагын дотоод хяналт хангалтгүй	1	-	-	-	1	-
Дүн	4	111,585.4	3	111,585.4	1	-
Нийт дүн	5	315,103.2	3	111,585.4	2	203,517.8



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 11/А0170433

Улаанбаатар хот

САГ-2026/150/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлаас түүвэрлэн горим сорил хэрэгжүүлэхэд албан хаагчдын цалинг тооцоходоо тайлант онд дотоод албан томилолтоор явсан 18 албан хаагчдад 2,915,000.00 /хоёр сая есөн зуун арван таван мянган/ төгрөгийн хоол, унааны зардлыг давхардуулан тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам" 2.1-т "Төрийн албан хаагчийг гадаад улсад болон нэг аймаг, хотоос нөгөө аймаг, хотод, түүнчлэн аймаг, хотын дотор өглөө ажилд очих, орой буцах боломжгүй газарт тухайн байгууллага болон дээд шатны удирдах байгууллагаас баталсан удирдамж, төлөвлөгөө, шийдвэрийн дагуу тодорхой хугацаагаар томилон ажиллуулсан нөхцөлд албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр олгоно", 2.2-т "Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөр дараах зардлаас бүрдэнэ: 2.2.1. унааны зардал, 2.2.2. байрны зардал, 2.2.3. хоолны зардал" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8 "...бусад нөхцөл байдал үүссэн"-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Албан хаагчдад илүү олгосон хоол, унааны зардал 2,915,000.00 /хоёр сая есөн зуун арван таван мянган/ төгрөгийг Монополын эсрэг газрын дарга /Б.Билгүүн/, нягтлан бодогч /Д.Одгэрэл/ нараар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд буцаан төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монополын эсрэг газрын дарга /Б.Билгүүн/-д хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Э.БАТ-ЭРДЭНЭ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230



Z:\khr\2026\0225 SAG-10.Docx

1526200045



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 72/А0170433

Улаанбаатар хот

САГ - 2026/150/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тайлант онд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг санхүүжилтийн эх үүсвэр, нэр төрөл, тендер шалгаруулалтын арга, төсөл, арга хэмжээ нэг бүрээр тусгаагүй бөөн дүнгээр нэгтгэж төлөвлөсөн, зарим төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авсан байна.

Мөн тайлант онд худалдан авсан 59,010,280.00 /тавин есөн сая арван мянга хоёр зуун наян/ төгрөгийн гэрээний дүнтэй бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагааны тайланд тусгаагүй, тайлагнаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1-т "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", 44.2-т "Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, үйлчилгээг тусгасан байна", 46 дугаар зүйлийн 46.1-т "Захиалагч худалдан авах ажиллагааны хэрэгжилт, үр дүнг тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрээр харьяалах дээд шатны төсвийн захирагчид цахим системээр тайлагнана", Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/250 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын 2.2-т "Захиалагч төлөвлөгөөг батлагдсан нийт төсөвт үндэслэн төсөл, арга хэмжээ нэг бүрээр энэ журмын хавсралтын 1 дүгээр маягтын дагуу цахим системд боловсруулна", 2.11-т "Захиалагч цахим системд нийтэлсэн төлөвлөгөөг мөрдөж ажиллах ба энэ журмын 2.12-т заасан үндэслэлээр батлагдсан төлөвлөгөөнд орсон нэмэлт, өөрчлөлтийг холбогдох шийдвэр гарснаас хойш ажлын 10 өдөрт багтаан төлөвлөгөөнд өөрчлөлтийг тусган, батална. Хэрэв холбогдох дээд шатны байгууллага байгаа бол төлөвлөгөөний өөрчлөлтийг түүгээр батлуулахаар цахим системээр илгээж, өөрчлөлтийг баталгаажуулна", 2.19-т "Захиалагч тухайн жилийн төлөвлөгөөг энэ журамд заасны дагуу цахим системд бүрэн оруулж, батлуулаагүй нь хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл болно", 3.11-т "Захиалагч тухайн жилийн худалдан авах ажиллагааны тайланг цахим системд бүрэн оруулж, батлуулаагүй нь хуульд заасан хариуцлага хүлээх үндэслэл байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол”-д заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээг бөөн дүнгээр нэгтгэж төлөвлөсөн, зарим төсөл, арга хэмжээг төлөвлөгөөнд тусгалгүйгээр худалдан авч байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монополын эсрэг газрын дарга /Б.Билгүүн/, нягтлан бодогч /Д.Одгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР		Э.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 73/А0170433

Улаанбаатар хот

САГ-2026/150/НА - СГА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах 52,575,120.00 /тавин хоёр сая таван зуун далан таван мянга нэг зуун хорин/ төгрөгийн төсөвт өртөгтэй бараа, үйлчилгээний техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалгүйгээр шууд гэрээ байгуулан худалдан авсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2-т "Энэ хуулийн 37.2.4-т тодорхойлсон захиалагч ерөнхий гэрээ байгуулсан бараа, үйлчилгээг энэ хуульд өөрөөр заагаагүй бол цахим дэлгүүрээс худалдан авна", 37 дугаар зүйлийн 37.1.2-т "хоёрдугаар үе шатанд захиалагч бараа, үйлчилгээг үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авах", 38.1-д "Ерөнхий гэрээний аргын хоёрдугаар үе шатанд захиалагч худалдан авах бараа, үйлчилгээний тоо хэмжээ, хүргэх газар, хуваарь бүхий захиалгын хуудсыг цахим системд илгээж, үнийн санал дуудаж цахим дэлгүүрээс худалдан авна", 49 дүгээр зүйлийн 49.4.3-т "ерөнхий гэрээ байгуулахтай холбоотойгоор энэ хуулийн 48.2.11-д зааснаас бусад захиалагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ", 14.2-т "Худалдан авах бараа, үйлчилгээний төрөл нэмэгдэх тохиолдолд энэ хуулийн 14.1-д зааснаар хүсэлтийг тухай бүр хүргүүлнэ", 14.4-т "Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно", Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно", Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 162 дугаар тушаалын 3-т "Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-15.Docx

1526180312

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.9 “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь энэ журмын 4.2.3-т заасан нөхцөл үүсээгүй бол”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ерөнхий гэрээний аргаар зохион байгуулах бараа, үйлчилгээний тендер шалгаруулалтад шаардагдах техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлээгүй, цахим дэлгүүрээс худалдан авалгүйгээр шууд гэрээ байгуулж байгаа зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монополын эсрэг газрын дарга /Б.Билгүүн/, нягтлан бодогч /Д.Одгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР		Э.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 74/АД170433

Улаанбаатар хот

САГ-2026/150/НА-СГА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус газар нь бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим гэрээнд ерөнхий байдлаар тусгасан, мөн худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдээгүй, худалдан авалтын гүйцэтгэл, гэрээний хэрэгжилтэд тавих хяналт сул байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 24 дүгээр зүйлийн 24.6-д "Төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний урсгал болон хөрөнгийн зардлыг төлөвлөх, гүйцэтгэлийн хяналт хийхдээ холбогдох норм, норматив, батлагдсан стандарт, зураг төсвийг үндэслэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана", 12.2-т "Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно", Иргэний хуулийн 195 дугаар зүйлийн 195.2-т "Гэрээ байгуулах саналд гэрээний гол нөхцөл буюу түүнийг тодорхойлох журмыг заасан байна" гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0125 SAG-15.Docx

1526180310

алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал"-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа ажлын даалгавар, техникийн тодорхойлолт, өртгийн тооцоог боловсруулаагүй, зарим төсөл, арга хэмжээг ерөнхий байдлаар боловсруулсан, худалдан авсан бараа, ажил, үйлчилгээг хүлээн авсан комиссын акт болон гэрээ дүгнэсэн актыг гэрээнд заасан хугацаанд үйлдэхгүй байгаа зөрчлүүдийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монополын эсрэг газрын дарга /Б.Билгүүн/, нягтлан бодогч /Д.Одгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР		Э.БАТ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 75/АД170433

Улаанбаатар хот

САГ - 2026/150/НА - СТА - ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монополын эсрэг газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөв захирагч нь Монгол Улсын Их Сургуультай 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдөр 500,000,000.00 /таван зуун сая/ төгрөгийн үнийн дүн бүхий судалгааны ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан боловч гэрээнд тусгасан нийт 7 нэр, төрлийн судалгааны ажлаас 2 судалгааны ажлын даалгаврыг боловсруулаагүй, төсвийн нарийвчилсан тооцоолол, өртгийн судалгааг хийлгүйгээр гэрээний үнийг шууд тогтоосон байна.

Мөн гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссан байхад талууд гэрээг дүгнээгүй, аудит гүйцэтгэж байх хугацаанд нэмэлт гэрээ нөхөж байгуулсан, судалгааны ажлаас 2 ажлыг огт хийгээгүй байхад төсөв захирагч төлбөрийг бүрэн олгохыг үүрэг болгосон, түүнчлэн бусад судалгааны ажлуудыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байхад алданги тооцоогүй, гэрээнд оюуны өмчийг эзэмших, ашиглах, баталгаажуулах, хориглох нөхцөл болон талуудын хооронд тохирсон бусад асуудлын талаар тусгаагүй. Үүний улмаас хүлээн авсан 5 судалгааны ажил тус бүрийн өртөг, үнийн дүнг тодорхойлох боломжгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана", 12 дугаар зүйлийн 12.2-т "Техникийн тодорхойлолтод бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэх түүхий эд, материал болон ажлын хүрээнд нийлүүлэх барааны шалгуур үзүүлэлтийг тодорхойлно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Засгийн газрын 2015 оны 267 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэсэн эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийг өмчлүүлэх, эзэмшүүлэх журам"-ын 4.2-т "Гэрээнд төслийг хэрэгжүүлэх хугацаа, нөхцөл, зардал, хүрэх үр дүн, оюуны өмч, түүнийг эзэмших, ашиглах, баталгаажуулах нөхцөл, оюуны өмчийг

ашиглахыг хориглох нөхцөл, журам, лицензийн нөхцөлөөр ашиглуулах болон талуудын хооронд тохирсон бусад асуудлыг тусгана”, 4.6-д “Захиалагч нь оюуны өмчийг байгууллагын нягтлан бодох бүртгэлийн холбогдох дансанд олон улсын ангилал, стандартын дагуу нэр, төрлөөр нь бүртгэж элэгдэл, хорогдлыг тооцно”, 5.2-т “Энэ журмын 5.1-д зааснаас бусад үр дүн буюу оюуны өмчтэй холбогдох тайлан, зураг, программ хангамж, интеграл микросхемийн зураглал, ноу-хау зэргийг төслийн захиалагч эзэмшиж, ашиглана”, Монополын эсрэг газар болон Монгол Улсын Их сургуулийн 2025 оны 8 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан 2025/Г-12 дугаар гэрээний 2.2-т “Ажил гүйцэтгэх ерөнхий хугацаа ажлын 90 хоног”, 3.1-т “Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт хөлс 500,000,000.00 /таван зуун сая төгрөг/ байна”, 3.3-т “Гүйцэтгэгч тал ажлыг бүрэн гүйцэтгэж захиалагч талд хүлээлгэн өгснөөр гэрээт ажлын үлдэгдэл 70 хувийн төлбөрийг ажлын 5 хоногт багтаан гүйцэтгэгч талын дансанд шилжүүлнэ”, 5.1-т “Гэрээнд заасан ажлыг тогтоосон хугацаанд гүйцэтгэнэ”, 6.1-т “Гүйцэтгэгч ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.5 хувийн алданги төлнө”, 6.2-т “Гэрээний аль нэг тал гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс үүдэн нөгөө талд болон бусдад учирсан хохирол, зардлыг бүрэн хариуцаж барагдуулна” гэж тус тус заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11 “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал”-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн тооцоолол, өртгийн судалгаа хийлгүйгээр гэрээний үнийг шууд тогтоосон, гэрээнд тусгасан ажлуудын ажлын даалгавар, техникийн тодорхойлолтыг бүрэн боловсруулаагүй, гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй зөрчлүүдийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дүгээр сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монополын эсрэг газрын дарга /Б.Билгүүн/, нягтлан бодогч /Д.Одгэрэл/ нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР		Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР		С.НАЦАГДОРЖ
АХЛАХ АУДИТОР		Э.БАТ-ЭРДЭНЭ